



СҮРЬЕЭГИЙН ЭСРЭГ ХАМТДАА

*(Хэсгийн ахлагч нарт зориулсан
гарын авлага)*

*Улаанбаатар хот
2021 он*

ӨМНӨХ ҮГ

Манай улсад сүрьеэгийн тохиолдлын түвшин нийт халдварт өвчний дотор бэлгийн замаар дамжих халдвар болон вируст гепатитийн дараа гуравдугаарт, харин нас баралтын түвшингээр нэгдүгээрт орж байна.

Сүрьеэ нь бол амьсгалын замаар халдварладаг нийгмийн халдварт өвчин. Нийгмийн халдварт өвчний хувьд сүрьеэгийн өвчлөл нас баралтыг бууруулахад бүх нийтийн оролцоо чухал. Засгийн газрын зүгээс “Сүрьеэгүй Монгол” зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд зорилтыг хэрэгжүүлэхэд дан ганц Өрхийн Эрүүл мэндийн төвийн хамт бус иргэдэд хамгийн ойрхон ажилладаг хороо, багийн засаг дарга, хэсгийн ахлагч та бүхний оролцоо маш чухал юм.

Хаана хэн хэрхэн амьдардаг, амьдралын нөхцөл байдал ямар байдаг, сүрьеэд хэн өртөж болох зэргийг хамгийн сайн мэдэж байгаагийн хувьд та бүхэн нийт иргэдээ сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах, сүрьеэтэй өвчтөнүүдийг эмчлэн эрүүлжүүлэхэд, Өрхийн эрүүл мэндийн төвтэйгээ хамтран идэвхитэй ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Энэ гарын авлага та бүхэнд Сүрьеэ өвчний талаар мэдлэг, мэдээлэлтэй болоход чухал хувь нэмэр оруулна

Хамтдаа төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, баг, хороогоороо сүрьеэгүй хамт олон болж, улмаар Сүрьеэгүй Монголын төлөө хамтран ажиллацгаая.

СҮРЬЕЭГИЙН ЭСРЭГ ХАМТДАА

Хэсгийн ахлагч нарт зориулан боловсруулсан анхны хэвлэл

Боловсруулсан: Д.Доржмаа, АУ-ны магистр
С. Цэвэл, БСУ-ны баклавар

Хянасан: Ш.Хажидмаа, АУ-ны магистр

Хэвлэлийн хуудас: 8
“Тоонот Принт” ХХК-д хэвлэв.
Цахим хаяг: toonot98@yahoo.com
Утас: 99093235



С.Ламбаа, МӨАУМХ-ны ерөнхийлөгч



СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ТАРХАЛТ

СҮРЬЕЭ ДЭЛХИЙ ДАХИНД

- Сүрьеэгээр **10** сая хүн өвчилж, **1.4** сая хүн нас баржээ.
- Сүрьеэ нь нас баралтын тэргүүлэх 10 шалтгааны нэг болж байна.
- Сүрьеэгээр өвчилсөн тохиолдлуудын **56%** нь эрэгтэйчүүд, **32%** нь эмэгтэйчүүд, **12%** нь хүүхэд байна.
- Сүрьеэгийн шинэ тохиолдлуудын **66.2%** нь 8 улс оронд бүртгэгджээ /Энэтхэг, Индонез, БНХАУ, Филиппин, Пакистан, Нигери, Бангладеш, Өмнөд Африк/.

Эх сурвалж: ДЭМБ, 2020 оны тайлан

СҮРЬЕЭ МОНГОЛ УЛСАД

- 2020 онд улсын хэмжээнд 31 төрлийн 33 376 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэний **10%** нь сүрьеэ байна.
- Улаанбаатар хотод бүртгэгдсэн амьсгалын замын цочмог халдварт өвчний **52.4%** нь сүрьеэ байна.
- Сүрьеэгээр **4432** хүн өвчилж, **213** хүн нас баржээ.
- Сүрьеэгээр өвчилсөн тохиолдлуудын **56%** нь эрэгтэйчүүд, **44%** нь эмэгтэйчүүд байна.
- 2020 онд улсын хэмжээнд 0-14 насны **397** хүүхэд сүрьеэгээр өвчилжээ.
- Сүрьеэгийн өвчлөл 25-34 нас /762/, 15-24 нас /691/, 35-44 нас/539/-д өндөр байна.
- Сүрьеэгийн шинэ тохиолдлуудын **59.4%** нь Улаанбаатар хотод, **38.5%** нь аймгуудад, **2.2%** нь Хориход бүртгэгджээ.

Эх сурвалж: ХӨСҮТ, тайлан 2020 он




СҮРЬЕЭГИЙН ТОХИОЛДЛЫН ТҮВШИН, 2020 ОН






СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ҮҮСГЭГЧ



- Сүрьеэ өвчин нь *Mycobacterium Tuberculosis* гэдэг нянгаар үүсгэгддэг.
- Сүрьеэгийн микобактери нь дараах онцлог шинжтэй. Үүнд:
 - Агаартай нөхцөлд цельсийн 35-38°C хэмийн дулаанд үрждэг.
 - Хүнд сүрьеэ өвчинг үүсгэнэ.
 - Өөрийн шинж чанараа өөрчлөх чадвартай. Өөрөөр хэлбэл хүний биед идэвхгүй хэлбэрт оршиж байснаа хүний дархлаа суларсан үед өвчин үүсгэдэг.
 - Сүрьеэгийн эмийн зохисгүй хэрэглээний улмаас эмэнд дасалтай болно.
 - Гадаад орчинд маш тэсвэртэй. Жишээлбэл: хасах 40°C хэмд 50-аас дээш жил амьд байх чадвартай.
 - Нарны шууд туяа, өндөр температур, хлор агуулсан бодисонд тэсвэргүй.





СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАР ДАМЖИХ ЗАМ



Уушгины хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн, сүрьеэгийн эмчилгээнд ороогүй байгаа өвчтөн ханиалгах, найтаах, ярих үед сүрьеэгийн нян агаарт цацагдана.

Эрүүл хүмүүс сүрьеэгийн нян агуулсан агаарын дуслуудыг амьсгалсанаар халдвар авна.




Биеийн эсэргүүцэл сайн тохиолдолд сүрьеэгийн нян хүний биед “унтаа” байдалд байна. Үүнийг сүрьеэгийн далд халдвар гэнэ.

Биеийн эсэргүүцэл сулрахад нянгууд идэвхжиж сүрьеэ өвчин үүснэ.






СҮРЬЕЭ ӨВЧИН ҮҮСЭХЭД ХҮНИЙ БИЕИЙН ДАРХЛАА БОЛОН ХАЛДВАРЛУУЛСАН НЯНГИЙН ХАРИЛЦАН НӨЛӨӨЛӨЛ



Биеийн
дархлаа

Маш бага
Бага
Болзошгүй
Маш их

Сүрьеэгээр
өвдөх эгзэг



Сүрьеэгийн
нянгийн тоо

- Сүрьеэгийн далд халдвартай хүн сүрьеэгээр өвчлөх нь халдварлуулсан нянгийн тоо болон хүний биеийн дархлааны харилцан нөлөөллөөс ихээхэн хамаарна.
- Хүний биеийн дархлаа сайн, биед байгаа сүрьеэгийн нянгийн тоо бага бол сүрьеэгээр өвчлөх магадлал бага байна.
- Хүний биеийн дархлаа сул, биед байгаа сүрьеэгийн нянгийн тоо их бол сүрьеэ өвчин үүсэх магадлал их байна.
- Сүрьеэгийн эмчилгээний дараа биед тогтвортой дархлаа үүсэхгүй тул дахин шинээр халдвар авбал сүрьеэ өвчнөөр давтан өвчлөх боломжтой.



СҮРЬЕЭГИЙН ДАЛД ХАЛДВАР БА СҮРЬЕЭ ӨВЧИН



Сүрьеэгийн далд халдвар:

- Ямар нэгэн зовиур шаналгаагүй, бусдад халдвар тараахгүй боловч сүрьеэгийн нян хүний биед оршсоор байхыг *сүрьеэгийн далд халдвар* гэнэ.
- Дэлхийн хүн амын гурван хүн тутмын нэг нь сүрьеэгийн далд халдвартай байна. Халдвар авсан эхний 2 жилд 5% нь өвчилдөг гэж үздэг.
- Халдвар авсан хүмүүсийн 10% нь л сүрьеэгээр өвчилдөг.



Сүрьеэ өвчин:

- Сүрьеэгийн нянгийн улмаас хүний биед үүссэн эмгэг байдлыг *сүрьеэ өвчин* гэнэ. Энэ үед сүрьеэ өвчний шинж тэмдэг илэрч, бусдад сүрьеэгийн халдварыг тараана.
- Жил бүр дэлхийн хэмжээнд 10 сая орчин хүн сүрьеэгээр өвчилж байна.
- Халдвартай хэлбэрийн буюу гадаад орчинд сүрьеэгийн нян ялгаруулж байгаа 1 өвчтөн жилд 10-15 хүнийг халдварлуулах эрсдэлтэй.
- Сүрьеэтэй оношлогдсон тохиолдол бүр эмчилгээнд хамрагдах шаардлагатай. Хэрэв сүрьеэтэй өвчтөнг эмчлэхгүй бол 50% нь 2-5 жилийн хугацаанд нас барах ба энэ хугацаандаа 20-75 хүнд халдвар тараах эрсдэлтэй.



СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАР АВАХ ЭРСДЭЛТЭЙ ХҮН АМ

Сүрьеэ нь хүнээс хүнд агаараар дамжиж халдварлах тул сүрьеэтэй өвчтөний гэр бүлийн гишүүд, хамт ажиллагсад, нэг анги танхимд хамт сурагсад халдвар авах эрсдэлтэй.



Сүрьеэгийн халдвар харанхуй, битүү, жижиг, агааржилт муутай газар тархана. Иймд хүн ам олноор бөөгнөрсөн эрсдэл өндөртэй орчинд ажиллаж амьдрагсад халдвар авах эрсдэлтэй /асрамжийн байр, түр саатуулах байр, цэргийн анги, хорих анги гэх мэт/



Эрсдэл өндөртэй үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээ үзүүлэгсэд сүрьеэгийн халдвар авах эрсдэлтэй.



СҮРЬЕЭГЭЭР ӨВЧЛӨХ ЭРСДЭЛТЭЙ ХҮН АМ



Сүрьеэтэй өвчтөний өрхийн болон ойрын хавьтал



Дархлал султай хүмүүс /ХДХВ-ийн халдвар, хавдар, чихрийн шижин, дархлал дарангуйлах эмчилгээ хийлгүүлж буй хүн гэх мэт/



Хоол тэжээлийн дутагдалтай хүн



Архи хэтрүүлэн хэрэглэгч



Тамхи татах хорт зуршилтай хүн




СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ШИНЖ ТЭМДЭГ



- **Ерөнхий шинж:** Сүрьеэ өвчний үед халуурах, бие зарайх, шөнө хөлрөх, ядрах, сульдах, хоолонд дургүй болох, турах зэрэг ерөнхий шинжүүд илэрдэг.
- Сүрьеэгийн нян нь хүний биеийн аль ч эрхтэнг гэмтээж болох ч ихэнх тохиолдолд уушгийг өвчлүүлдэг. Уушгины сүрьеэгийн үед ерөнхий шинжүүдээс гадна ханиалгах, цустай цэр гарах, амьсгаадах шинж илэрдэг.
- Уушгинаас бусад эрхтэнд байршилтай сүрьеэгийн үед илрэх шинж нь тухайн эрхтэний онцлогоос хамаарна. Тухайлбал:
 - о Яс, үений сүрьеэ: үеэр өвдөх, хавдах
 - о Нүдний сүрьеэ: нүд бүрэлзэх, нүд улайх
 - о Захын булчирхайн сүрьеэ: булчирхай томрох
 - о Гэдэсний сүрьеэ: хэвлийгээр өвдөх, дотор муухайрах, бөөлжих, өтгөн хатах, заримдаа гүйлгэх
 - о Шээс ялгаруулах эрхтэний сүрьеэ: шээх тоо олшрох, шээхэд өвдөх, шээс цустай гарах



СҮРЬЕЭГИЙН ОНОШИЛГОО



- Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг Өрхийн эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансери, Халдварт өвчин судлалын үндэсний төвд үнэ төлбөргүй хийдэг.
- Сүрьеэгийн далд халдварыг туберкулины сорил, интерферон гамма тодорхойлох шинжилгээгээр илрүүлнэ.
- Сүрьеэ өвчнийг түрхэц болон өсгөврийн, молекул биологийн, багажийн шинжилгээ (цээжний рентген шинжилгээ, компьютерт томографи)-ээр оношилдог.
- Цэр, ходоодны угаадас, плеврийн шингэн, үений шингэн, тархи нугасны шингэн, өтгөн, шээс зэрэг биологийн сорьцонд сүрьеэгийн нянг илрүүлнэ.



СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭ



Эмчилгээний явцад уураг, нүүрс ус, өөх тос, А, Д, Е, В6 аминдэм, цайр, селени, төмөр зэрэг бичил элементүүдээр баялаг хоол хүнс хэрэглэнэ.

Өвчтөн бүрт сүрьеэ өвчний тухай эрүүл мэндийн боловсрол олгож, сэтгэлзүйн зөвлөгөө өгнө.



Сүрьеэгийн эмийн эмчилгээ 6-12 сар үргэлжилдэг ба эмчилгээнд 3-4 төрлийн эмийг эмчийн заавраар өдөр бүр ууна.

Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлнэ. Халдвар ялгаруулахаа больсон үед эмчилгээг сүрьеэгийн диспансери, өрхийн эрүүл мэндийн төв, сайн дурын идэвхтэний хяналтад эмчилгээг үргэлжлүүлнэ.



Сүрьеэгийн эмийг эмчийн зааврын дагуу өдөр бүр уухгүй бол эмэнд тэсвэртэй сүрьеэ үүсэх, өвчин хүндрэх, нас барах, халдварыг бусдад тараах аюултай.



ЭМЧИЛГЭЭ ХИЙЛГЭЖ БАЙХ ҮЕД АНХААРАХ АСУУДЛУУД

Эмийн гаж нөлөө

- Сүрьеэгийн эмийг уух үед хоолонд дургүй болох, дотор муухайрах, бөөлжих, арьс салст шарлах, үеэр өвдөх, гар хөл бадайрах, арьс салт шар өнгөтэй болох, биеэр тууралт гарах зэрэг шинж илэрч болно. Эмийн гаж нөлөөг эмчлэгч эмчдээ заавал мэдэгдэх хэрэгтэй.

Эмчилгээний хяналтын шинжилгээ

- Уушгины сүрьеэгийн эмчилгээний явцыг хянах, эмчилгээний үр дүнг тооцох зорилгоор эмчилгээ хяналтын 2 (3), 5, 6, 9 (12) дэх саруудад цэрний шинжилгээ хийлгэнэ.
- Сүрьеэгийн эмийн тунг биеийн жинд тохируулан тооцдог тул өвчтөний биеийн жинг сар бүр хэмжинэ.
- Сүрьеэгийн нянгийн улмаас уушгинд гарсан өөрчлөлтийг хянах зорилгоор эмчилгээний эхэнд, дунд болон төгсгөлд цээжний рентген зураг авахуулна.

Өрхийн хавьтлыг үзлэгт хамруулах

- Сүрьеэгийн эмчилгээ эхлэхээс өмнөх 3 сарын хугацаанд нэг орон байран хамт амьдарч байсан хүнийг *өрхийн хавьтал* гэнэ.
- Өрхийн хавьтал биш боловч тухайн тохиолдлын халдвартай байх хугацаанд /анги танхим, ажлын байр, асрумажийн газар, хорих газар гэх мэт/ хамт байсан хүнийг *ойрын хавьтал* гэнэ.
- Сүрьеэтэй оношлогдсоноос хойш 14 хоногийн дотор цаашид 2 жилийн турш жилд 1 удаа бүх хавьтлыг сүрьеэ илрүүлэх үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна.



ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ



Сүрьеэгийн эмэнд дасалтай нянгаар үүсгэгдсэн хэлбэр юм. Энэ нь сүрьеэгийн эм сүрьеэ өвчнийг үүсгээд байгаа нянг устгаж чадахгүй болно гэсэн үг.

Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөн өдөрт 5-7 төрлийн 7-16 ширхэг эмүүдийг 9-24 сарын турш ууж байж эдгэрдэг.




Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний явцад дотор муухайрах, бөөлжих, хоолны дуршил буурах, гүйлгэх, үеэр өвдөх, арьс, салст шар өнгөтэй болох, шөрмөс татах, хараа муудах, арьс бор өнгөтэй болох гэх мэт гаж нөлөө илэрдэг.

Удаан хугацааны эмчилгээ, эмийн гаж нөлөө, халдвар ялгаруулалт, ялгаварлан гадуурхалт зэргийн улмаас өвчтөнд сэтгэц, нийгмийн тулгамдсан асуудал үүсдэг.



СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ЯВЦАД ҮҮСЭХ СЭТГЭЦ, НИЙГМИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

- Өвчний зовиур, удаан хугацааны эмчилгээ, эмийн гаж нөлөөний улмаас сүрьеэтэй өвчтөний хөдөлмөрийн чадвар алдагдаж улмаар ажил эрхлэлтэд нь өөрчлөлт гарч, санхүүгийн тогтвортой байдал нь алдагддаг байна.
- Эмчилгээний явцад сүрьеэтэй өвчтөнүүд тогтмол орлогогүй болсоны улмаас хүнсний хомсдолд орж биемахбодид шаардлагатай шим тэжээлээ хоол хүнсээрээ авч чаддаггүй. Энэ нь эдгэрэлтэд сөргөөр нөлөөлдөг.
- Ард иргэдийн сүрьеэ өвчний тухай мэдлэг хангалтгүйн улмаас сүрьеэтэй өвчтөн гэр бүл, нийгэм, ажлын хамт олон, сургуулийн орчин, найз нөхдийн хүрээнд ялгаварлан гадуурхалтад өртдөг.





МИНИЙ ТҮҮХ



...Би нөхөртөө ОЭТС-ээр өвчилсөн гэдгээ хэлсэн. Гэтэл хадам ээж маань нөхөр бид хоёрыг салгасан. Одоо нөхөр маань хүүтэйгээ тусдаа амьдарч байгаа. Би хоёр охинтойгоо хамт өөрийнхөө ээжийн гэрт амьдарч байна... (29 настай эмэгтэй)

...Намайг ОЭТС-ээр өвчилсөн гэдгийг мэдээд хүүхдүүд маань их цочирдсон. Охин маань уйлж, хүү маань хэдэн өдөр дуугаа хураасан. Нөхөр маань их гайхсан. Манай нөхөр намайг сайн ойлгож, их халамжилдаг. Энэ өвчинг ялан дийлэхэд гэр бүлийн дэмжлэг үнэхээр чухал юм байна... (49 настай эмэгтэй)



...Намайг ОЭТС-ээр өвчилсөн гэдгийг манай хорооныхон мэддэг. Гэрийнхээ хажуугийн дэлгүүрт орохоор худалдагч эгч над руу байнга муухай харж, бараагаа бараг л шидэж өгдөг. Намайг дэлгүүрээсээ хурдхан гараасай гэж байгаа юм шиг ханддаг... (19 настай, эрэгтэй)



МИНИЙ ТҮҮХ



...Манай сургууль дээр олон хүүхэд сүрьеэгээр өвчилсөн. Сургуулийнхаа хажуугийн шүдний эмнэлэгт үзүүлэх гэтэд “Танай сургуулийнхан сүрьеэгээр өвчилсөн гэсэн. Чамд үйлчлэх боломжгүй” гэж хэлээд намайг эмнэлгээсээ гаргасан. Уг нь шүдний эмчилгээний 3 дахь үзлэг байсан юм... (15 настай, эмэгтэй)

...Сүрьеэгээр өвчилсөнг маань мэдсэнийхээ дараа манай ажлынхан намайг гадуурхаж эхэлсэн. Багш нарын өрөөнд орохоор бүгд дэр хийтэл босоод надтай зөрөөд өрөөнөөс гараад явчихдаг. Эсвэл өрөөнийхөө цонхыг онгойлгодог. Заримдаа ажлаасаа гармаар санагддаг. Даанч би гэртээ ажил хийдэг ганц хүн нь. Амаргүй байна... (49 настай, эмэгтэй)



... Намайг сүрьеэгээр өвчилсөнийг манай ангийнхан мэдэж байгаа. Миний хажууд хүүхэд суухаа больсон. Би ангийнхаа хамгийн ард ганцаараа суудаг. Миний хажуугаар гарахдаа хүүхдүүд ам, хамраа дардаг. Би ганцаардаж байна... (16 настай, эмэгтэй)



МИНИЙ ТҮҮХ



...Сүрьеэгээр өвдөхөөсөө өмнө банканд ажилладаг байсан. Ажлаасаа өөрийнхөө хүсэлтээр гарсан. Бусдад халдвар тараахгүй юмсан гэж л бодсон. Эмчилгээгээ дуусгачихаад шинэ ажил хайж олно доо ...

(25 настай, эмэгтэй)

...Сүрьеэгээр өвчилсөн гэдгээ багш нартаа хэлсэн. Багш маань намайг “Эмчилгээгээ сайн хийлгээд эрүүл бол. Хичээлдээ санаа зовоод хэрэггүй” гэсэн. Манай ангийнхан надад хичээлийн лекц явуулж хоцрогдолгүй байлгах гэж хичээдэг. Би эмнэлгээс гараад сургуульдаа явна. Сургууль завсардахгүй, хичээлдээ санаа зовохгүй болохоор санаа амар байна...



(20 настай, эрэгтэй)




... Эхлээд ах маань, дараа нь би сүрьеэгээр өвчилсөн. Эмнэлгээс гарчихаад сургуульдаа явахад хүүхдүүдийн хандах хандлага өөр болсон нь мэдрэгдсэн. Харах харц нь өөр болсон байсан. Уралдаан тэмцээнд оруулахгүй, уулзалтад дуудахгүй, зайгаа авсан. Сайхан санагдаагүй. Надад маш муухай мэдрэмж төрсөн...

(15 настай, эмэгтэй)



МИНИЙ ТҮҮХ



...Сүрьеэгээр өвчилсөн гэдгээ найз нартаа хэлсэн. Найз нарын маань тоо цөөрсөн. Уулздаг найз ховордсон...

(26 настай, эмэгтэй)

...Би их олон найзтай. Сүрьеэгээр өвчилсөнөө хэлтэл найзууд маань надаас зай авч эхэлсэн. Найз нөхөд худлаа л байдаг юм байна. Одоо миний хажууд гэр бүлийнхэн маань л үлдсэн. Хүнд хамгийн чухал зүйл гэр бүл гэдгийг одоо ойлголоо...



(47 настай, эрэгтэй)



... Эмнэлэгт хэвтэж байхад гайгүй л байсан. Эмнэлгээс гарсныхаа дараа л ялгаварлан гадуурхалтыг мэдэрч эхэлсэн. Найзууд маань намайг “Чи турсан байна, чиний нүүр харалсан байна” гэхээр миний дургүй хүрдэг. Уулздаг найз ховордсон. Уулзъя, ярилцъя гэхээр янз бүрийн шалтаг тоочоод татгалздаг. Надаас дөлж байгаа нь мэдрэгддэг...

(34 настай, эмэгтэй)



ХАМТАРСАН БАГ

Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Өрхийн Эрүүл мэндийн төв, хороо, багийн ажлын албаны “Хамтарсан баг” байгуулж ажиллах шаардлагатай байна.

Зорилго

Баг, хорооны иргэдэд үзүүлэх сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх, хавьтлыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах, эмчилгээний тасалдлыг арилгахад хамтарч ажиллах

Багийн зохион байгуулалт

- Хорооны засаг дарга
- Нийгмийн ажилтан
- Халамжийн ажилтан
- Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга
- Сүрьеэгийн тусламж үйлчилгээ хариуцсан зохицуулагч




СҮРЬЕЭГИЙН ТАРХАЛТЫГ БУУРУУЛАХАД БИД ХАМТДАА ЮУГ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэх арга замууд
Хүн амын дунд сүрьеэгийн тархалт өндөр байна.	Сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын дунд сүрьеэг илрүүлэх үзлэгийг тогтмол зохион байгуулах
Сүүлийн жилүүдэд эмчилгээний явцад хяналт алдагдсан буюу эмчилгээ тасалсан өвчтөнүүдийн тоо ихсэж байна.	Хяналт алдагдсан өвчтөнг хайж олоод, эмчилгээгээ үргэлжлүүлэх шаардлагатай тухай тайлбарлаж ойлгуулах Өвчтөн эмээ уухгүй байгаа саадыг тодруулж, эмчилгээг үргэлжлүүлэхэд шаардагдах арга хэмжээг авах
Эмчилгээний явцад сүрьеэтэй өвчтөний санхүүгийн тогтвортой байдал алдагдаж байна.	Сүрьеэтэй өвчтөнг зохих нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах /хоол хүнсний талон, түлш олгох гэх мэт/
Сүрьеэтэй өвчтөн гэр бүл, нийгэм, хамт олон, найз нөхдийн хүрээнд ялгаварлан гадуурхалтад өртөж байна	Хүн амд сүрьеэ өвчний тухай үнэн зөв мэдээлэл түгээх
Хүн амын сүрьеэ өвчний талаарх мэдлэг дадал хандлага хангалтгүй байна.	Иргэдэд сүрьеэ өвчний талаар эрүүл мэндийн боловсрол олгох
Сүрьеэгийн тусламж үйлчилгээ нь олон талт хамтын үйл ажиллагаа тул төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах хэрэгтэй байна.	Баг, хороон засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн ХАМТАРСАН БАГ сүрьеэгийн тусламж үйлчилгээнд оролцох



Уушгины сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээний алгоритм



а-Эмнэлзүйн оношлогоо /эмнэлзүйн багийн шийдвэр- холбогдох нэмэлт шинжилгээг хийх/

Тайлбар: Энэхүү алгоритмыг сүрьеэгийн идэвхитэй илрүүлэлт, хавьтлын үзлэг шинжилгээ (18-аас дээш настай), даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ болон эрүүлзүйн үзлэг шинжилгээний үед мөрдөнө.